

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН БОЛОН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН
АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР
/нөөцөөс/**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/48 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Нийслэл дэх Төрийн аудитын газрын нийцлийн аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер, санхүүгийн аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежерийн албан тушаалын сонгон шалгаруулалтыг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс зарлаж байна.

1. Сонгон шалгаруулалтад оролцох иргэн нь Төрийн албаны тухай хуулийн 10.1-д заасан ерөнхий шаардлага болон томилох эрх бүхий этгээдийн баталсан ажлын байранд тавигдах дараах шаардлагыг хангасан байна.

Тухайн ажлын байранд тавигдах шаардлага:

Нийцлийн аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер:

	Чухал шаардлагатай	Шаардлагатай
Боловсрол	Дээд боловсролын бакалавр зэрэгтэй	Магистр зэрэгтэй
Мэргэжил	Нягтлан бодогч, эдийн засагч, төрийн удирдлагын менежер, бусад	
Мэргэшил	Төрийн болон бизнесийн удирдлагын менежер, өөрийн мэргэжлээр зөвлөгчийн хэмжээнд байна.	
Туршлага	Төрийн албанд 7-аас доошгүй, удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан	
Ур чадвар	-Хууль зүйн зохих мэдлэгтэй байх; -Монгол хэл бичгийн болон албан хэрэг хөтлөлтийн ур чадвар эзэмшсэн байх; -Баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах чадвартай байх; -Компьютерийн өргөн хэрэглээний болон санхүүгийн программыг бүрэн эзэмшсэн байх; -Удирдан зохион байгуулах чадвартай байх; -Судалгаа, шинжилгээний ажлын туршлагатай байх	
Тусгай шаардлага	-Гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх; -Багаар ажиллах чадвартай байх; -Төр, улсын болон байгууллага, иргэдийн нууцыг хадгалах; -Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй байх; -Харилцааны соёлтой байх;	

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер:

	Чухал шаардлагатай	Шаардлагатай
--	---------------------------	---------------------

Боловсрол	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш	Магистрийн зэрэгтэй
Мэргэжил	Санхүүч, Эдийн засагч, Нягтлан бодогч	
Мэргэшил	Санхүү, Хяналт, аудит, шинжилгээ, судалгааны чиглэлээр мэргэшсэн;	Мэргэшсэн нягтлан бодогч
Туршлага	Мэргэжлээрээ болон төрийн албанд 7-оос доошгүй жил ажилласан	
Ур чадвар	-Хууль зүйн зохих мэдлэгтэй байх; -Монгол хэл бичгийн болон албан хэрэг хөтлөлтийн ур чадвар эзэмшсэн байх; -Баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах чадвартай байх; -Компьютерийн өргөн хэрэглээний болон санхүүгийн програмыг бүрэн эзэмшсэн байх; -Удирдан зохион байгуулах чадвартай байх; -Судалгаа, шинжилгээний ажлын туршлагатай байх	
Тусгай шаардлага	-Гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх; -Багаар ажиллах чадвартай байх; -Төр, улсын болон байгууллага, иргэдийн нууцыг хадгалах; -Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй байх; -Харилцааны соёлтой байх;	

Сонгон шалгаруулалтыг 2017 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулна.

2. Сонгон шалгаруулалтын бүртгэл:

Сонгон шалгаруулалтад орох иргэний баримт материалыг Үндэсний аудитын газрын 310 тоот өрөөнд 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр 09.00-12.30, 13.30-17.00 цагуудад хүлээн авч, бүртгэнэ. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэн дор дурьдсан материалыг бүрдүүлэн **өөрийн биеэр ирж** бүртгүүлнэ. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн анкет (маягт №1);
2. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;
3. Иргэний үнэмлэх;
4. Төрийн албаны мэргэшлийн шалгалт өгсөн материал;
5. Тангарагын хуудас;
6. Ажилласан жилийг тооцох хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эх хувийн хамт;
7. Ажил байдлын тодорхойлолт;
8. 4х3 хэмжээтэй 2 хувь цээж зураг;

Дээрх баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

3. Сонгон шалгаруулалтыг Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/48 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын

удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулах журам"-ын дагуу зохион байгуулна.

4. Сонгон шалгаруулалтад орох иргэдээс дараах шалгалтыг авна.

а/ ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох /25 асуулттай сорилын шалгалт/;

б/ ур чадварын түвшин тогтоох/албан хэрэг хөтлөлт, компьютер/;

в/ ярилцлага хийх;

5. Сонгон шалгаруулалтад төрийн албаны мэргэшлийн шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн иргэд хамрагдана.

6. Сонгон шалгаруулалтад орох иргэдийн уншиж судлах эрх зүйн баримт бичиг

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтын хүрээнд бэлтгэсэн “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын сорилгын хураамж” Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн номын худалдаанд зарагдаж байгаа бөгөөд сонгон шалгаруулалтад орох иргэд дараах жагсаалтад байгаа хууль, журмаас бэлдэнэ үү. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль,
3. Төрийн албаны тухай хууль,
4. Төрийн нууцын тухай хууль,
5. Авлигын эсрэг хууль,
6. Төрийн хяналт шалгалтын тухай хууль,
7. Хөдөлмөрийн тухай хууль,
8. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,
9. Байгууллагын нууцын тухай
10. Татварын ерөнхий хууль,
11. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
12. Хувь хүний нууцын тухай
13. Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
14. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль,
15. Шилэн дансны тухай хууль,
16. Архивын тухай хууль,
17. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай
18. Төсвийн тухай хууль
19. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.
20. Захиргааны ерөнхий хууль /2016.07.01/
21. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2016.07.01/
22. Нийтийн сонсголын тухай хууль
23. Төрийн аудитын тухай хууль
24. Хууль тогтоомжийн тухай хууль
25. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэ

ХАРИЛЦАХ ХАЯГ: ЗАСГИЙН ГАЗРЫН 4 ДҮГЭЭР БАЙР, ӨРӨӨ 310, УТАС 99061237

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ДЭРГЭДЭХ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН КОМИСС